



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЯНТЭЭГ ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ӨВА-2026/03/НА-СТА-ОНӨҮГ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Өвөрхангай аймаг,  
Арвайхээр сум

2026 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: [Batjargalo@audit.gov.mn](mailto:Batjargalo@audit.gov.mn)

Аудитын менежер: П.Хорлоосүрэн

Утас: 70323833 Цахим хаяг: [Khorloosuren@gmail.com](mailto:Khorloosuren@gmail.com)

Аудитор: Ц.Мөнхзаяа

Утас: 70323108 Цахим хаяг: [Munkhzhayats@audit.gov.mn](mailto:Munkhzhayats@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

---

АГУУЛГА	
1. Хараат бус аудиторын дүгнэлт .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	9
3.1 Төлбөрийн акт .....	9
3.2 Албан шаардлага .....	9
3.3 Зөвлөмж .....	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	10

#### Товчилсон үгийн жагсаалт

УСНББО	
УС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1. Хараат бус аудиторын дүгнэлт



### ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.15 № 139  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянтээг хувьцаат компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Баянтээг хувьцаат компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон зүйл

Баянтээг хувьцаат компани нь 2025 онд нийт 13,308.4 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүнд: Үндсэн үйл ажиллагааны орлого 13,213.7 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 44.9 сая төгрөг, хүүгийн орлогоос 49.8 сая төгрөгийн орлого олж борлуулалтын өртөг 7,933.8 сая төгрөг, урсгал зардалд 1,439.1 сая төгрөг, гадаад валютын ханшийн зөрүүний гарз 24.9 сая төгрөгийг зарцуулж 3,910.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Тайлант хугацаанд нийт 950.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс өөрийн хөрөнгөөр 107.3 сая төгрөгөөр худалдан авч, 499.0 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Баянтээг түлш орон нутгийн өмчит ХХК татан буугдаж тус байгууллагын 842.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 77.4 сая төгрөгийн бараа материал нийт 920.1 сая төгрөгийг өмнөх оны авлага бууруулж авсан байна.

#### Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг.

Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно. Бусад мэдээллийн талаар онцлог анхаарал татсан зүйлгүй байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	1	1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,980,148,831	12,564,163,582.11
2	31	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,809,693,393	7,282,883,536.11
3	31100	1.1.1.01 Кассанд байгаа бэлэн мөнгө	15,693,915.4	476,744
4	31110	1.1.1.01.01 Төгрөг	15,693,915.4	476,744
5	31200	1.1.1.02 Банкинд байгаа бэлэн мөнгө	3,793,999,477.6	7,282,406,792.11
6	31210	1.1.1.02.01 Төгрөг	3,793,999,477.6	7,282,406,768.43
7	31213	1.1.1.02.01.03 Арилжааны банк дахь харилцах	3,793,999,477.6	7,282,406,768.43
8	31220	1.1.1.02.02 Гадаад валют	0.0	23.68
9	31223	1.1.1.02.02.03 Арилжааны банк дахь харилцах	0.0	23.68
10	33	1.1.3 АВЛАГА	2,181,727,722	1,310,540,063
11	33100	1.1.3.01 Ажиллагчидтай холбогдсон авлага	1,804,442	1,000,000
12	33401	1.1.3.05 Дансны авлага /ТӨҮГ/	2,151,983,646	1,309,530,429
13	33402	1.1.3.06 Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	27,939,634	9,634
14	34	1.1.4 УРЬДЧИЛГАА	3,380,436,664	3,380,436,664
15	34600	1.1.4.06 Урьдчилж гарсан зардал	3,380,436,664	3,380,436,664
16	35	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	608,291,052	590,303,319
17	35200	1.1.5.02 Дуусаагүй үйлдвэрлэл	0.0	77,339,691
18	35300	1.1.5.03 Бэлэн бүтээгдэхүүн	81,666,417	0
19	35400	1.1.5.04 Хангамжийн материал	526,624,635	512,963,628
20	35410	1.1.5.04.01 Бичиг хэргийн материал	0.0	1,560,454
21	35420	1.1.5.04.02 Аж ахуйн материал	0.0	67,872,421
22	35430	1.1.5.04.03 Сэлбэг хэрэгсэл	286,871,383	331,468,246
23	35440	1.1.5.04.04 Түлш, шатах тослох материал	199,606,703	70,929,860
24	35450	1.1.5.04.05 Барилгын засварын материал	40,146,549	9,866,363
25	35460	1.1.5.04.06 Хүнсний материал	0.0	14,358,227
26	35470	1.1.5.04.07 Бусад хангамжийн материал	0.0	16,908,057
27	2	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,957,570,489	6,408,578,222.99
28	39	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,957,570,489	6,408,578,222.99
29	39200	1.2.2.02 Биет хөрөнгө	5,083,856,813	5,521,587,846.99
30	39201	1.2.2.02.01 Барилга, байгууламж, орон сууц	1,950,390,920	2,552,006,847
31	39202	1.2.2.02.02 Хуримтлагдсан элэгдэл	-1,568,875,120	-1,571,947,354
32	39203	1.2.2.02.03 Авто-тээврийн хэрэгсэл	2,896,421,819	2,997,221,819
33	39204	1.2.2.02.04 Хуримтлагдсан элэгдэл	-1,018,384,327	-1,257,419,924
34	39205	1.2.2.02.05 Машин тоног төхөөрөмж(компьютер)	5,225,363,116	5,443,466,097.44
35	39206	1.2.2.02.06 Хуримтлагдсан элэгдэл	-4,226,197,288	-4,471,665,449
36	39207	1.2.2.02.07 Тавилга, аж ахуйн эд хогшил	158,575,709	174,656,040.55

**Баянтээг ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

37	39208	1.2.2.02.08 Хуримтлагдсан элэгдэл	-85,649,142	-96,941,356
38	39214	1.2.2.02.14 Бусад үндсэн хөрөнгө	1,752,211,126	1,752,211,126
39	39300	1.2.2.03 Биет бус хөрөнгө	62,152,620	75,429,320
40	39301	1.2.2.03.01 Програмын хангамж	63,098,800	63,846,800
41	39302	1.2.2.03.02 Хуримтлагдсан элэгдэл	-946,180	-1,095,880
42	39303	1.2.2.03.03 Бусад биет бус хөрөнгө	0.0	12,678,400
43	39400	1.2.2.04 Бусад хөрөнгө /ТӨҮГ/	811,561,056	811,561,056
44	39402	1.2.2.04.02 Хайгуул ба үнэлгээний хөрөнгө /ТӨҮГ/	811,561,056	811,561,056
45	3	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	15,937,719,320	18,972,741,805.1
46	4	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,863,443,496	987,901,092.4
47	41	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,092,002,592	700,052,477.4
48	41300	2.1.1.03 Өглөг	1,092,002,592	700,052,477.4
49	41360	2.1.1.03.06 Бусад өглөг	1,092,002,592	700,052,477.4
50	41363	2.1.1.03.06.03 Татварын өглөг /ТӨҮГ/	251,816,847	578,578,102.4
51	41365	2.1.1.03.06.05 Ноогдол ашгийн өглөг /ТӨҮГ/	339,036,930	0.0
52	41366	2.1.1.03.06.06 Дансны өглөг /ТӨҮГ/	501,148,815	121,474,375
53	42	2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	771,440,904	287,848,615
54	42200	2.1.2.02 Урт хугацаат зээл	771,440,904	287,848,615
55	42210	2.1.2.02.01 Төгрөг	771,440,904	287,848,615
56	42214	2.1.2.02.01.04 Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	771,440,904	287,848,615
57	5	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,074,275,824	17,984,840,712.7
58	51	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	14,066,697,524	17,984,840,712.7
59	51101	2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/	17,682,500	17,682,500
60	51102	2.2.1.03 Өмч /хувийн/ /ТӨҮГ/	0.0	7,578,300
61	51106	2.2.1.07 Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	415,167,428	415,167,428
62	51200	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	13,062,033,887	16,972,598,775.7
63	51210	2.2.1.08.01 Өмнөх үеийн үр дүн	13,015,160,093	13,062,033,887
64	51220	2.2.1.08.02 Тайлант үеийн үр дүн	46,873,794	3,910,564,888.7
65	51300	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	571,813,709	571,813,709
66	52	2.2.2 Хяналтын бус хувь оролцоо	7,578,300	0
67	6	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	15,937,719,320	18,972,741,805.1

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

төгрөгөөр

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
1	I	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,921,239,766	5,374,574,714
2	12	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,921,239,766	5,374,574,714
3	120	1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	1,921,239,766	5,374,574,714
4	1201	1.1.1.04.1.02 Хүүгийн орлого	91,758,393	49,799,880

**Баянтээг ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

5	120002	1.1.1.04.1.02.02 Бусад хүүгийн орлого	91,758,393	49,799,880
6	120004	1.1.1.04.1.04 Төсөв байгууллагын өөрийн орлого	11,531,965,909	13,258,614,926
7	1200041	1.1.1.04.1.04.01 Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,476,318,500	13,213,719,000
8	1200042	1.1.1.04.1.04.02 Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	55,647,409	44,895,926
9	120009	1.1.1.04.1.09 Бусад орлого	190,000,000	0.0
10	120011	1.1.1.04.1.11 Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	9,892,484,536	7,933,840,092
11	II	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,867,408,723	1,439,087,957.3
12	21	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,867,408,723	1,439,087,957.3
13	210	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,867,408,723	1,439,087,957.3
14	2108	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,867,408,723	1,439,087,957.3
15	210810	1.1.2.01.1.08.10 Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	240,909	0.0
16	210811	1.1.2.01.1.08.11 Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	1,861,959,615	1,001,811,651
17	210814	1.1.2.01.1.08.14 Орлогын татварын зардал /ТӨҮГ/	5,208,199	437,276,306.3
18	III	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	53,831,043	3,935,486,756.7
19	V	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,957,249	24,921,868
20	225004	1.2.2.03 Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	6,957,249	24,921,868
21	VII	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-6,957,249	-24,921,868
22	VI	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	46,873,794	3,910,564,888.7
23	VI-I	2 Засгийн газрын хувь оролцоо	32,811,656	0
24	VI-II	3 Хяналтын бус хувь оролцоо	14,062,138	0.0

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

төгрөгөөр

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
1	I	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	16,156,556,928	14,511,972,344
2	12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,156,556,928	14,511,972,344
3	120	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	16,156,556,928	14,511,972,344
4	1201	1.1.1.1.04.1.02 Хүүгийн орлого	91,758,394	49,799,880
5	120002	1.1.1.1.04.1.02.02 Бусад хүүгийн орлого	91,758,394	49,799,880
6	120004	1.1.1.1.04.1.04 Төсөв байгууллагын өөрийн орлого	16,064,798,534	14,462,172,464
7	1200041	1.1.1.1.04.1.04.01 Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,064,798,534	14,462,172,464
8	II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,711,741,181	10,552,485,812.89
9	21	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	15,711,741,181	10,552,485,812.89
10	210	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,711,741,181	10,552,485,812.89
11	2101	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,535,337,910	2,049,335,781

Баянтээг ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

12	210106	1.1.1.2.01.1.01.06 Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	1,535,337,910	2,049,335,781
13	2102	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	522,822,810	0.0
14	210206	1.1.1.2.01.1.02.06 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	522,822,810	0.0
15	2103	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	337,238,953	194,686,220
16	210305	1.1.1.2.01.1.03.05 Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	337,238,953	194,686,220
17	2104	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	5,430,510,601	1,706,328,353
18	210409	1.1.1.2.01.1.04.07 Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	1,575,887,429	1,472,083,021
19	210410	1.1.1.2.01.1.04.08 Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	3,854,623,172	234,245,332
20	2108	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,885,830,907	6,602,135,458.89
21	210815	1.1.1.2.01.1.08.10 Хүүний төлбөр төлсөн /ТӨҮГ/	9,994,521	0.0
22	210816	1.1.1.2.01.1.08.11 Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	1,770,374,822	1,100,811,566
23	210817	1.1.1.2.01.1.08.12 Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	2,187,450	1,193,922
24	210818	1.1.1.2.01.1.08.13 Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	6,103,274,114	5,500,129,970.89
25	III	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	444,815,747	3,959,486,531.11
26	V	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	711,262,686	0
27	22	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	711,262,686	0
28	2200	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	711,262,686	0
29	225106	1.1.2.2.01.1.06 Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	711,262,686	0
30	VI	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-711,262,686	0
31	14	1.1.3.1 Бусад эх үүсвэр	600,000,000	0.0
32	145007	1.1.3.1.04 Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	600,000,000	0.0
33	25	1.1.3.4 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,272,243,869	486,296,388
34	250001	1.1.3.4.01 Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	6,957,249	24,921,868
35	250002	1.1.3.4.02 Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө	600,000,000	0.0
36	250005	1.1.3.4.05 Төлсөн ногдол ашиг	665,286,620	461,374,520
37	VII	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-672,243,869	-486,296,388
38	VIII	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-938,690,808	3,473,190,143.11
39	101	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,748,384,201	3,809,693,393
40	20	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,809,693,393	7,282,883,536.11

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Устгалын өмнөх			
			1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	630,428,228	571,813,709	14,123,765,044	15,326,006,981
2	2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	2,870,249	2,870,249
3	3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	630,428,228	571,813,709	14,126,635,293	15,328,877,230
4	5	1.1.1.1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-190,000,000	0.0	0.0	-190,000,000
5	8	1.1.1.1.6 Зарласан ногдол ашиг	0.0	0.0	-1,111,475,200	-1,111,475,200
6	9	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	46,873,794	46,873,794
7	10	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	440,428,228	571,813,709	13,062,033,887	14,074,275,824
8	11	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	440,428,228	571,813,709	13,062,033,887	14,074,275,824
9	13	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	440,428,228	571,813,709	13,062,033,887	14,074,275,824
10	19	1.7 Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	3,910,564,888.7	3,910,564,888.7
11	20	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	440,428,228	571,813,709	16,972,598,775.7	17,984,840,712.7

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн зөрчилд албан шаардлага-2, зөвлөмж -3 хүргүүлээ. Үүнд

### Залруулсан алдаа:

Аудитын явцад залруулга хийгдээгүй.

### 3.1 Төлбөрийн акт

Тус байгууллага дээр акт гараагүй.

### 3.2 Албан шаардлага

Илрүүлэлт-1:

Нийт 4,091,3 мянган төгрөгийн авлага, 26,528.1 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь-1:

Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт-2:

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 63,846.8 мянган төгрөгийн программ хангамжийг тоолж, тооцоо бодож баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь-2:

Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

### 3.3 Зөвлөмж

Илрүүлэлт-1:

**Баянтээг ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Тус байгууллагад бүртгэлтэй 11 газрыг орлогод аваагүй, Баянтээг түлш ХХК-иас шилжиж ирсэн бараа материал, үндсэн хөрөнгийг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцэж нягталж хүлээж аваагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тус байгууллагад бүртгэлтэй газрыг санхүүгийн тайланд тусгах

2. Баянтээг түлш ХК-иас шилжиж ирсэн хөрөнгийг тулган шалгаж шаардлагатай арга хэмжээг хуулийн дагуу зохион байгуулах

Илрүүлэлт-2:

Эд хариуцагчийн тайланд тавих хяналт хангалтгүй, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь 2:

Дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Анхан шатны маягт хөтлөлтийг сайжруулах

2. Эд хариуцагчийн тайланг тулган шалгах

3. Хөрөнгийн тооллогыг журмын дагуу зохион байгуулж тооцоо бодсон актыг бүрэн хөтлөх

Илрүүлэлт-3:

Тайлант онд шилэн дансны цахим сайтад 11 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь 3:

Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд нь байршуулах

**Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.**

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
							Залруулсан		Залруулаагүй				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Алдаа гараагүй													
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	00	00	0	0

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	

**Баянтээг ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	Тоо	Дүн	Т о о	Дүн	Т о о	Дүн	Т о о	Д ү н	Тоо	Албан тушаал тны тоо	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 63,846.8 мянган төгрөгийн программ хангамжийг тоолж, тооцоо бодож баталгаажуулаагүй байна	1	63,846.8			1	63,846.8						
Нийт 4,091,3 мянган төгрөгийн авлага, 26,528.1 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	30,619.4			1	30,619.4						
Эд хариуцагчийн тайланд тавих хяналт хангалтгүй, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна	1						1					
ус байгууллагад бүртгэлтэй 11 газрыг орлогод аваагүй, Баянтээг түлш ХХК-иас шилжиж ирсэн бараа материал, үндсэн хөрөнгийг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцэж нягталж хүлээж аваагүй байна.	1						1					
<b>ДҮН</b>	<b>3</b>	<b>94,466.2</b>			<b>2</b>	<b>94,466.2</b>	<b>1</b>					

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>						
Тайлант онд шилэн дансны цахим сайтад 21 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна	1				1	
<b>Дүн</b>	<b>1</b>				<b>1</b>	
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>						
<b>Нийт дүн</b>						

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
2026 оны 3 дугаар сарын 13

